

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ
/Том Байгууллагын зээл/

2022 оны 03-р
сарын 28-ны өдөр

№ 3Г22/13

Улаанбаатар хот

07-2022/130

ЭНЭХҮҮ ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ-г

- Нэг талаас “ХААН Банк” ХХК буюу түүнийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Стадион Оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, ХААН Банк цамхаг хаягт орших, Байгууллагын Банк Хариуцсан Дэд Захирал **Т.Ууганбаяр** /цаашид “Банк” гэх/;
- Нөгөө талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв 302 тоот хаягт орших, улсын бүртгэлийн **9010001097** дугаартай, регистрийн **5435528** дугаартай, **Эрдэнэс Тавантолгой ХК**, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай, регистрийн ФМ75081915 дугаартай, Монгол Улсын иргэн Борчууд ургийн овогт Баттулгын Ганхуяг (цаашид “Зээлдэгч” гэх, гэрээнд оролцогчдыг хамтад нь “Талууд” гэх) нар нь Монгол улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг үндэслэн талууд хүсэл зоригтоо чөлөөтэй илэрхийлж, энэхүү гэрээнд заасан нөхцөлийг харилцан зөвшөөрснөөр байгуулсан болно.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэ гэрээний зорилго нь Банк Зээлдэгчид тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг хугацаатай, хүүтэй, барьцаа батлан даалттай, тодорхой зориулалтаар, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээлдүүлэх, Зээлдэгч Банкны зээлийн нөхцөлийг хүлээн зөвшөөрч зээл авах, буцаан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээнд заасан нэр томъёонуудыг дараах утгаар ойлгоно.
- 1.2.1. **Зээлийн хүү**- Зээлийг ашигласан хугацаанд гэрээнд заасан хэмжээгээр тооцох Зээлдэгчийн хариу төлбөр буюу зээлийн үнийг;
- 1.2.2. **Нэмэгдүүлсэн хүү**- Зээлдэгч зээлийн гэрээний 2.1.7 болон “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-т заасан дэд хугацаанд хуваарьт зээлийн төлбөрөө эргүүлэн төлөөгүй тохиолдолд нэмж төлөхөөр тохиролцсон энэхүү гэрээний 2.1.6-д заасан хүүг;
- 1.2.3. **Зээлийн төлбөр**- Зээл, зээлийн хүү, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүү, зээл төлөхтэй холбоотой гарсан бусад төлбөр, хураамжийг;
- 1.2.4. **Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь**- Зээл олгох, зээлийн төлбөрийг эргүүлэн төлөх хэмжээ, хугацааг заасан талуудын тохиролцоог;
- 1.2.5. **Зээлийн гэрээний хугацаа**- Гэрээний 2.1.7 болон “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-т заасан хуваарьт хугацаануудыг;
- 1.2.6. **Зээлийн гэрээний хугацааг хэтрүүлэх**- Зээлийн гэрээний хугацаанд зээлийн төлбөрөө бүрэн төлөөгүй байхыг;
- 1.2.7. **Гадаад валют**- ам.доллар, юань, еврог;
- 1.2.8. **Зээлийн эргэн төлөлтийн харьцаа**- Хүү, элэгдэл, татварын өмнөх ангийг тухайн жилд төлөх нийт зээлийн төлбөрт харьцуулсан харьцааг;
- 1.2.9. **Ноцтой сөрөг нөлөө**- Зээлдэгчийн үйл ажиллагаа, биет ба биет бус хөрөнгө, компанийн зах зээлийн үнэлгээ, санхүүгийн нөхцөл байдал, эсхүл энэхүү Гэрээний дагуу буюу бусад холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд үзүүлэх сөрөг нөлөөг;

ХОЁР. ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 2.1. **Зээлийн хэмжээ, зориулалт, олголт, хүү, хугацаа**
- 2.1.1 Зээлийн хэмжээ: **70,000,000,000.00 /Далан гэрбум/** төгрөг байна.
/тоогоор / /үсгээр/
- 2.1.2 Зээлийг **Эргэлтийн хөрөнгийн** зориулалтаар ашиглана.
- 2.1.3 Зээл олголт:
- 2.1.3.1 Зээлийн дансны дугаар: **5038104502**
- 2.1.3.2 Зээл олгох хэлбэр: Зээлдэгчийн ХААН Банк дахь **5004020197** тоот төгрөгийн дансанд бэлэн бусаар эсвэл бүх зээл олголтыг Зээлдэгчийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдийн дансруу (*дансны мэдээллийг Зээлдэгч тухай бүрт өгч байх*) шууд шилжүүлснээр зээлийг олгосонд тооцно.
- 2.1.3.3 Зээлийг зориулалтаас нь хамааруулан хэсэгчлэн олгож болох бөгөөд энэ тохиолдолд “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг Хавсралт 1-ээр харилцан тохиролцоно.
- 2.1.3.4 “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу зээлийг хэсэгчлэн олгох тохиолдолд Зээл олголт хийх тухай хүсэлтээ гэрээний Хавсралт 2 загварын дагуу бичгээр, эсвэл энэ гэрээнд заасан баталгаат цахим хаягаар баталгаажуулан ирүүлнэ. Ингэхдээ гэрээний 2.2 дахь хэсэгт заасан болон доорх шаардлагыг хангасан байна.
 - (а) Зээл олгох хүсэлтийг зээл авахыг хүссэн өдрөөс ажлын нэг хоногийн өмнө Банкинд хүргүүлэх;
 - (б) Өмнө олгогдсон зээлүүдийг зориулалтын дагуу ашигласан тухай тайлан ирүүлсэн байх;
 - (в) Энэхүү зээлтэй холбогдуулан Банкинд гаргаж буй бүх мэдэгдэл, баталгаа эсхүл бусад зүйлс үнэн зөв байх;
 - (г) Ямар нэг ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц болон үзүүлж болохуйц ямарваа нэг зүйл тохиолдоогүй байх;
 - (д) Зээл олгох өдрийн байдлаар зөрчилд тооцогдох аливаа нөхцөл, байдал бий болоогүй эсхүл үйлдэл хийгдээгүй байх;
 - (е) Энэхүү гэрээний 2.1.4 дахь хэсэгт заасан үргэлжлүүлэн олгохыг зогсоох нөхцөл үүсээгүй.
 - (ё) Банкан дахь дансууд нь хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэрээр битүүмжлэгдээгүй байх;
Зээл олгох гүйлгээ хийхийн өмнө Банкан дахь дансууд нь хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэрээр битүүмжлэгдсэн эсэхийг шалгана. Хэрэв Банкан дахь бүх данс нь битүүмжлэгдсэн байх тохиолдолд зээл олгох гүйлгээ хийхгүй бөгөөд Зээлдэгчид энэ талаар мэдэгдэнэ.
- 2.1.4 Зээл олголтыг зогсоох: Зээлдэгч зээлийг зориулалт бусаар ашигласан, ажил үүргээ хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгээгүй, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсон, ямар нэг ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц болон үзүүлж болохуйц нөхцөл байдал үүссэн гэж Банк үндэслэлтэйгээр үзсэн, энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах барьцаа хөрөнгийн өмчлөх эрхийг бусдад шилжүүлсэн, барьцаа хөрөнгийг давхар барьцаалуулсан тохиолдолд зээлийн гэрээний хугацааны хэдийд ч зогсоож, зээлийг үргэлжлүүлэн олгохоос татгалзана.
- 2.1.5 Зээлийн хүү: Жилийн **15.0 /Арван таван/** хувь байна. Жилийн 365 хоногоор төлөөлүүлэн тооцно.

- 2.1.6 Эргэн төлөлтийн хуваарийг 30 хоногоор хугацаа хэтрүүлсэн тохиолдолд 31 дэх хоногоос зээлийн гэрээний 2.1.5-д заасан зээлийн хүүг 1.2%-р өсгөж, жилийн 16.2% болохоор талууд харилцан тохиролцсон бөгөөд зээлийн нийт үлдэгдэл төлбөрийг бүрэн барагдуулах хүртэл 16.2% н хүүг мөрдөх болно.
- 2.1.7 Нэмэгдүүлсэн хүү: Зээлийн хүүгийн 20/Хорин/ хувь байна. Нэмэгдүүлсэн хүүг “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу төлөгдөөгүй үндсэн зээлийн дүнгээс тооцно.
- 2.1.8 Зээлийн гэрээний хугацаа: 9 сар. Зээл анх олгосон өдрөөс эхлэн хугацааг тоолно. Зээлдэгч зээлийг хэсэгчлэн авах, зээлийн төлбөрийг Зээлийн гэрээний хугацааны дотор хэсэгчлэн төлөх хуваарийг Банктай “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-т заасны дагуу тохиролцоно.
- 2.2 Зээлдэгч дараах нөхцөлүүдийг хангаж, “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг Хавсралт 1-ээр харилцан тохиролцож байгуулснаар Банк ажлын 2 өдрийн дотор Зээлийг олгох бөгөөд дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд зээлдэгчийг гэрээний үүргээ биелүүлэгчид тооцон зээл олгохоос татгалзана.
- 2.2.1 Банкны шаардсан баримт бичгүүдийг Банкнд хүргүүлсэн байх;
- 2.2.2 Гэрээний 2.2.1-2.2.3-т заасан нөхцөлүүдийг 2022 оны 05-р сарын 27-ны өдрийн дотор биелүүлсэн байх;
- 2.2.3 Банкн дахь данснууд нь хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэрээр битүүмжлэгдсэн байх; Зээл олгох гүйлгээ хийхийн өмнө Банкн дахь данснууд нь хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэрээр битүүмжлэгдсэн эсэхийг шалгана. Хэрэв Банкн дахь бүх данс нь битүүмжлэгдсэн байх тохиолдолд зээл олгох гүйлгээ хийхгүй бөгөөд Зээлдэгчид энэ талаар мэдэгдэнэ.
- 2.3 Зээлийн үйлчилгээний шимтгэл
- 2.3.1 Зээл олгох үйлчилгээний шимтгэл: Олгосон зээлийн дүнгийн 1/нэг/ хувь буюу 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 2.3.2 Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах үйлчилгээний шимтгэл: Төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл дүнгийн 1/нэг/ хувь буюу 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 2.4 Зээлийн эргэн төлөлт
- 2.4.1 Энэхүү гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд зээлийн хүүг сар тутамд, зээлийг гэрээний 2.1.1-т заасан хэмжээгээр Хавсралт 1-т заасан “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу хуваарьт өдрийн 22.00 цагаас өмнө үл маргах журмаар эргүүлэн төлнө;
- 2.4.2 Зээлийн төлбөрийг “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу хуваарьт өдрийн 22.00 цагаас өмнө төлөөгүй тохиолдолд дараах зарчмыг тус тус баримтална.
- 2.4.2.1 “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-аас урьдчилан, эсхүл илүү дүнгээр төлсөн тохиолдолд зээлийн төлбөр гүйцэтгэсэн өдөр хүртэл хугацаанд тооцогдсон зээлийн хүүг төлүүлж, үлдсэн дүнгээр үндсэн зээлийг төлүүлнэ;
- 2.4.2.2 “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-аас хугацаа хэтрүүлэн, эсхүл дутуу төлсөн тохиолдолд зээлийн төлбөр гүйцэтгэсэн өдөр хүртэл хугацаанд тооцогдсон нэмэгдүүлсэн хүү, уг хугацаанд тооцогдсон зээлийн хүүг тус тус төлүүлж, үлдсэн дүнгээр үндсэн зээлийг төлүүлнэ;
- 2.5 Зээлдэгч зээлийн гэрээний хугацаанд багтаан зээлээ бүрэн төлөөгүй бол Зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүг толно.
- 2.6 Зээлдэгч төгрөгөөр авсан зээлийг гадаад валютаар төлөх бол төлбөр хийх тухайн өдрийн Банкны худалдаж авах ханшаар, гадаад валютын зээлийг төгрөгөөр төлөх тохиолдолд тухайн өдрийн Банкны зарах ханшаар тус тус тооцно.
- 2.7 Банк “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу Зээлдэгчийн харилцах данснаас зээлийг үл маргах журмаар төлүүлэх ба тухайн дансанд зээл төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний мөнгө байхгүй тохиолдолд Зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн бусад данснаас зээлийн төлбөрийг үл маргах журмаар бэлэн бусаар төлүүлнэ.
- 2.8 Зээлдэгч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд Банк зээлийн гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, олгосон зээлийг нэн даруй буцаан төлөхийг Зээлдэгчээс шаардана.

ГУРАВ. МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА, ЗӨВШӨӨРӨЛ

- 3.1 Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч нь Банкнд дараах мэдэгдэл, баталгаа гаргаж байна. Үүнд:
- 3.1.1 Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн мөн бөгөөд энэхүү гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх бүрэн эрх, холбогдох итгэмжлэл, зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан;
- 3.1.2 Үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах бүх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл нь хууль ёсны бөгөөд хуульд заасан хугацаандаа сунгуулах, гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуустал хүчин төгөлдөр хэвээр байна;
- 3.1.3 Энэхүү гэрээ болон Барьцааны гэрээг байгуулах, гэрээнд заасан нөхцөлийг биелүүлэхийг зогсоох, хойшлуулах, саад болох эрхийг Зээлдэгч болон Хамтран үүрэг гүйцэтгэгчийн дүрмийн заалт, Хувьцаа эзэмшигчид, ТУЗ, Гүйцэтгэх захирлын баталсан тогтоол шийдвэр, шүүхийн шийдвэр, гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээгээр ямар ч этгээдэд олгоогүй болно;
- 3.1.4 Монгол Улсын Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдлын болон Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, бусад хууль, тэдгээртэй холбогдож гаргасан эрх зүйн бусад актын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;
- 3.1.5 Эд хөрөнгийг өмчлөх маргаангүй эрхтэй, тэдгээрийг Зээлдүүлэгчийн өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгосноос бусад өөр барьцаа, баталгаанд бариулаагүй, барьцаа хөрөнгө нь аливаа өр төлбөр, зардал, барьцаа, анз зэргээс чөлөөтэй байгаа, гэрээний биелэлтэд саад болох, хойшлуулах, хууль бус болгох, зогсооход хүргэж болзошгүй Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн эсрэг нэхэмжлэлтэй шүүхийн, захиргааны эсхүл арбитрын шүүхийн хэрэг үүсээгүй, шийдвэр гараагүй болно;
- 3.1.6 Энэхүү Гэрээг байгуулах өдөр буюу түүнээс өмнөх хугацаанд Банкнд мэдэгдээгүй ямар нэгэн өр, төлбөр, түүнтэй холбоотой хэрэг маргаан, үүрэг, хариуцлага байхгүй;
- 3.1.7 Зээл авах үеийн байдлаар аудитлагдсан болон аудитлагдаагүй Санхүүгийн нэгдсэн тайланг, эсвэл тухайн компанийн дотоод санхүүгийн тайлан болон татварын тайланг Банкнд хүргүүлсэн болно. Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргах бөгөөд Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн тайлан тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, эзэмшигчийн өмчийн өөрчлөлтийн тайлан, бэлэн мөнгөний тайлан, эдгээр тайланд Зээлдэгчийн гуравдагч этгээдүүдэд төлөх ёстой бүх өр төлбөрийг үнэн зөв тусгасан болно;
- 3.1.8 Зээлдэгч татварын болон нийгмийн даатгалын бүх төлбөл зохих татвар, шимтгэлийг төлсөн;
- 3.1.9 Энэхүү Гэрээтэй холбогдуулан Зээлдэгчээс Банкнд гаргасан ямарваа мэдэгдэл, тайлан эсхүл бусад баримт бичиг нь бодит байдлыг гуйвуулсан худал мэдээлэл агуулаагүй бөгөөд уг баримт бичиг дэх мэдээллийн талаар төөрөгдөлд оруулахгүй байхад шаардлагатай бодит баримтыг орхигдуулаагүй.

- 3.2 Зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нь дараах зөвшөөрлийг Банкнд энэхүү гэрээгээр олгосон бөгөөд дахин бичгээр зөвшөөрөл авах шаардлагагүй болно. Үүнд:
- 3.2.1 ХААН Банк дахь дансаас Зээлийн төлбөр болон бусад төлбөрийг суутган авах;
- 3.2.2 Ямар нэг ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц болон үзүүлж болохуйц аливаа нөхцөл байдал үүссэн гэж Банк үзсэн тохиолдолд Зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн дансуудад битүүмж хийх бөгөөд зээлийн төлбөрийг “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг үл харгалзан шууд суутгах;
- 3.2.3 Хууль, энэ гэрээнд заасан үндэслэлээр зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч болон барьцаалуулагчийн мэдээллийг бусад гаргаж өгөх, зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зээлийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх;
- 3.2.4 Зээлийн гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд ШШГЕГазар, УБЕГазар болон бусад холбогдох байгууллагаас мэдээлэл авах;
- 3.2.5 Банк энэхүү гэрээний 6.1-д заасны дагуу гэрээг цуцалсан тохиолдолд Зээлдэгчийн бизнесийн болон хувийн нэр төрд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан халдах, бусад шаардлагатай аливаа арга хэмжээ авах;
- 3.2.6 Зээлийн төлбөр төлөхтэй холбоотой аливаа төлбөр тооцоог Банкны тухайн үед мөрдөгдөж буй хүү, шимтгэлийн нөхцөлөөр гүйцэтгэхийг зөвшөөрч байна. Гэрээ байгуулснаас хойш Банкны дээрх шимтгэл хураамжийн нөхцөл өөрчлөгдсөн бол тэрхүү нөхцөлийг баримтална.
- 3.2.7 Даатгалд хамрагдсан тохиолдолд даатгалын компаниас нөхөн төлбөр олгохтой холбоотой шаардсан мэдээллийг гаргаж өгөхийг зөвшөөрч байна.
- 3.2.8 Чалко /Chalco Trading Hong Kong Co., Limited/ компанитай байгуулсан А-11-040-2020Q1 тоот гэрээ болон ЕТТ-2019/340, ЕТТ-2019/592, ЕТТ-2019/593 тоот гэрээнүүдийн орлогын нэхэмжлэлд ХААН Банкны 5004020200 тоот дансыг тусгах, орлогыг тус дансаар 100 хувь дамжуулахыг зөвшөөрч байна;
- 3.2.9 Талуудын хооронд байгуулсан барьцааны гэрээнд туссан Нүүрс худалдах, худалдан авах тухай ЕТТ-2019/340 тоот, ЕТТ-2019/592 тоот, ЕТТ-2019/593 тоот гэрээнүүдийн хугацааг 2022 оны 04 дүгээр сард багтаан сунгаж, гэрээний орлогыг ХААН Банкны 5004020200 тоот дансаар дамжуулахаар тусгахыг зөвшөөрч байна;
- 3.2.10 Зээл хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээний орлогын 100 хүртэл хувиар зээлийн төлөлт хэвийн болгох хүртэл “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг харгалзахгүйгээр зээлийн төлбөрийг төлөхийг зөвшөөрч байна.
- 3.2.11 Бусад банк, банк бус санхүүгийн байгууллагаас ХААН Банкны зээлийг оруулан нийт 400 тэрбум төгрөгөөс хэтэрсэн нэмэлт зээл авах тохиолдолд ХААН Банканд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авна;
- 3.2.12 Зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг, эд хөрөнгө хуваарилахгүй байхыг зөвшөөрч байна.

ДӨРӨВ. ЗЭЭЛДЭГЧ, ХАМТРАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Зээлдэгчийн эрх:
- 4.1.1 Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсноор гэрээнд заасан нөхцөлөөр зээлийг авч ашиглах;
- 4.1.2 Зээлийн дансны гүйлгээний хуулга, баримтыг авах;
- 4.1.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах;
- 4.1.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн нөхцөлд Банкны зээлийн журмын дагуу дахин зээл авах, бусад урамшуулалд хамрагдах;
- 4.1.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр барьцаа хоронгоо чөлөөлж авах;
- 4.2 Зээлдэгчийн үүрэг:
- 4.2.1 Зээлийн төлбөрийг сар бүр **5004020197** тоот тогрогийн харицах дансандаа төвлөрүүлж “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу толох бөгөөд төлбөрийн баримтад гүйлгээний утгыг тодорхой бичих;
- 4.2.2 Зээлийг зориулалтын дагуу ашиглах, Банкнаас зээлд хяналт тавих, газар дээр нь биелэлт танилцах бүхий л боллоцоо нөхцөлийг хэдийд ч бүрдүүлж, шаардсан мэдээ мэдээллээр хангах;
- 4.2.3 Зээлийн төлбөр, бусад төлбөр тооцоогоо Банкаар дамжуулан гүйцэтгэх;
- 4.2.4 Бодит болон тооцоолсон мөнгөний урсгалыг хэдийд ч Зээлдэгчийн үйл ажиллагааны зардал болон Зээлийн төлбөрийг төлбөл зохих хугацаанд нь төлөхөд хүрэлцэхүйц хэмжээнд байлгах;
- 4.2.5 Зээлийг хэсгчлэн авах тухай бүрт ашигласан зээлийн зарцуулалтын тооцоог нотлох баримт материалын хамт гаргаж Банкнд тайлагнах;
- 4.2.6 Зээлийн гэрээний үүргийг бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд зээл олгох үед даатгуулсан даатгалын эрсдэлийн төрлүүдээр даатгалын гэрээг тухай бүр сунгуулах, хүчин төгөлдөр байлгах;
- 4.2.7 Зээлдэгчид урьдчилан тооцоолох боломжгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн мөнгөн хөрөнгөөс нэн тэргүүнд зээлийн төлбөр, бусад төлбөрийг төлөх;
- 4.2.8 Дансан дахь мөнгөн хөрөнгө нь зээлийн төлбөр, зээлтэй холбогдон гарах бусад төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд барьцааны зүйлээр тэргүүн ээлжинд төлбөрийг барагдуулах;
- 4.2.9 Зээлийн гэрээний үүргийг бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд барьцааны зүйлийг үргэдүүлэх, чанар байдлыг алдагдуулах болон үнэлгээ буурах бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд Банкны шаардсаны дагуу нэмж хөрөнгө барьцаалуулах, бусад хөрөнгөөрөө зээлийн төлбөрийг барагдуулах;
- 4.2.10 Зээлийг буцаан төлүүлэх мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд зээлийн төлбөрийг заасан хугацаанд гүйцэтгэх;
- 4.2.11 Энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ Банкны бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй;
- 4.2.12 Энэхүү гэрээнд тусгасан хэлцлүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй гэж Банкны үзсэн бусад бүх баримт бичигт гарын үсэг зурж, Банкнд өөрийн зардлаар хүргүүлж, тийм бүх үйлдлийг өөрийн зардлаар цаашид хийлгэх;
- 4.2.13 Зээлийг урьдчилж хаах тохиолдолд 7.2-д зааснаар шимтгэлийг төлөх;
- 4.2.14 Зээлийн өрийг барагдуулаагүй байх хугацаанд Зээлдэгч нь дор дурдсан мэдээллийг Банкнд өгөхөө үүгээр батлан, зөвшөөрч байна. Үүнд:
- (а) Аудитаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан (баланс, орлого, үр дүнгийн тайлан, эзэмшигчдийн өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тэмдэглэлүүд)-г тухайн санхүүгийн жил дуусгавар болсноос хойш 120 (нэг зуун хорь) хоногийн дотор;

- (б) Урьдчилан гаргасан жилийн төсвийг Зээлдэгчийн санхүүгийн жил эхлэхээс 60 (жар) хоногийн өмнө өгөх бөгөөд шинэчилсэн жилийн төсвийг бизнес төлөвлөгөөний хамт Зээлдэгчийн санхүүгийн жил эхлэхээс хойш 60 (жар) хоногийн дотор;
- (в) Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал дууссанаас хойш 45 (дөчин тав) хоногийн дотор улирал бүр;
- (г) Зээлдэгчийн санхүүгийн асуудалтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэлүүдийн хуулбар;
- (д) Зээлдэгчид хүргүүлсэн аудиторын удирдлагын захидлын хуулбар болон бусад хөндлөнгийн санхүүгийн тайлангийн хуулбар;
- (е) (1) Ямарваа зөрчил үүссэн (ингэхдээ мөн уг зөрчлийн нөлөөг арилгах эсхүл бууруулах үүднээс авч буй буюу авах гэж буй арга хэмжээний талаар Банкинд мэдээлнэ); (2) Засгийн газрын аливаа тохируулагч байгууллагатай эсхүл хууль хэрэгжүүлэгч байгууллагатай үүсгэсэн маргаан, хөдөлмөрийн маргаан эсхүл ноцтой сөрөг нөлөө үзүүлэх эсхүл үзүүлж болохуйц өөр бусад нөхцөл байдлыг шийдвэрлэх аливаа шүүхийн, захиргааны, арбитраж маргаан (үүнд аливаа гуравдагч этгээдийн нэхэмжлэл эсхүл хариуцлагыг хамааруулах боловч үүгээр хязгаарлагдахгүй) зэрэг нөхцөл байдлын талаар мэдсэн даруйдаа Банкинд бичгээр мэдэгдэх;
- (ё) Зээлийн ашиглалтын талаарх мэдээллийг зээл олгосноос хойш 1 сарын дотор;
- (ж) Харилцагч Банкаа өөрчилсөн, харилцах данс шинээр нээлгэсэн бол;

- 4.2.15 Зээлдэгч нь Зээлийн аливаа өр төлөгдөөгүй байгаа тохиолдолд Банкны урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах зүйлүүдийг хийхгүй гэдгээ үүгээр батлан зөвшөөрч байна. Үүнд:
- (а) Барьцааны зүйлийг худалдах, эсхүл түүнтэй холбогдуулан гуравдагч этгээдийн эрх, барьцааны эрх бий болгох буюу бий болгохыг зөвшөөрөх;
 - (б) Аливаа нэгдмэл сонирхолтой этгээд, эсхүл гуравдагч этгээд, эсхүл аливаа өөр этгээдэд зээл эсхүл баталгаа (хүлээж болзошгүй үүрэг буюу бусад) олгох;
 - (в) Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч, батлан даагчийн хаяг, хуулийн этгээдийн оноосон нэр, зөвшөөрөл, хувьцаа эзэмшигчид, дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, гишүүнчлэл, удирдлага, зохион байгуулалт, саналын эрх зэргийг Банкны зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй;
 - (г) Аливаа өөр хуулийн этгээдтэй нэгдэх, хуваах, нийлүүлэх, өөрчлөн байгуулах, түүнийг худалдан авах, зөвшөөрөх буюу хэрэгжүүлэх эсхүл түншлэл, хамтарсан компанид нэгдэн орох, хамтран хувь нийлүүлэн ажиллах эсхүл дүрэмдээ өөрчлөлт оруулах;
 - (д) Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч үйл ажиллагааг нь өөр этгээд удирдах удирдлагын гэрээ эсхүл үүнтэй төстэй хэлцэл байгуулах ёсгүй.
- 4.2.16 Энэхүү зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалуулсан барьцаа хөрөнгийн өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, давхар барьцаалуулах бол холбогдох гэрээг байгуулахаас өмнө гэрээний 2.4.1-т зааснаас үл хамааран нийт төлбөл зохих зээлийн үлдэгдэл, тооцогдсон хүү, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүг буцаан төлөх;
- 4.2.17 Энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг банкинд барьцаалуулсан бол энэ гэрээний зүйл заалтуудыг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчид нэг бүрчлэн танилцуулах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа хохирлыг барагдуулна;
- 4.2.18 Зээлдэгч нь хувьийн этгээд бол олгосон зээлийг өөрийн санхүүгийн тайланд тусгаж, энэ талаарх мэдээллийг Банканд өгөх үүрэгтэй. Хэрэв зээлдэгч нь Mongol Улсын хувь тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд бөгөөд хувьцаа санхүүгийн тайлан гаргах үүрэг хэргэсэн бол энэ заалт нэгэн ажил хамаарна.
- 4.2.19 Чалко /Chalco Trading Hong Kong Co., Limited/ компанид байгуулсан А-11-040-202001 тоот гэрээ болон ЕТТ-2019/340, ЕТТ-2019/592, ЕТТ-2019/593 тоот гэрээний орлогын нэхэмжлэл ХААН Банкны 5004020200 тоот дансыг тусгах, орлогыг тус дансаар 100 хувь дамжуулах.
- 4.2.20 Талгудын хооронд байгуулсан барьцааны гэрээнд туссан Нүүрс худалдах, худалдан авах тухай ЕТТ-2019/340 тоот, ЕТТ-2019/592 тоот, ЕТТ-2019/593 тоот гэрээний хугацааг 2022 оны 04 дүгээр сард багтаан сунгаж, гэрээний орлогыг ХААН Банкны 5004020200 тоот дансаар дамжуулахаар тусгах.
- 4.2.21 Зээл хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээний орлогын 100 хүргэл хувиар зээлийн төлөлт хэвийн болгох хүртэл “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг харгалзахгүйгээр зээлийн төлбөрийг төлөх.
- 4.2.22 Бусад банк, банк бус санхүүгийн байгууллагаас ХААН Банкны зээлийг оруулан нийт 400 тэрбум төгрөгөөс хэтэрсэн нэмэлт зээл авах тохиолдолд ХААН Банканд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах.
- 4.2.23 Зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг, эд хөрөнгө хуваарилахгүй байх.

ТАВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Банкны эрх:

- 5.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, зохих ёсоор биелүүлэхийг Зээлдэгчээс шаардах;
- 5.1.2 “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу болон хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг Банкн дахь харилцах данснаас, харилцах данс дахь мөнгөн хөрөнгө хүрэлцэхгүй бол Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн бусад дансаас үл маргах журмаар суутган авах; эдгээр дансаас төлбөр хийх боломжгүй бол Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэж Банкн дахь хугацаатай хадгаламжийн дансанд битүүмж хийн, мэдэгдэл дурьдсанаар үл маргах журмаар зээлийн төлбөрийг суутган авах;
- 5.1.3 Даатгалын болон бусад нөхөн төлбөрөөр тэргүүнээлжинд зээлийн төлбөр барагдуулахыг шаардах;
- 5.1.4 Барьцааны зүйл үрэгдсэн, чанар байдал алдагдсан болон үнэлгээ буурах бусад нөхцөл байдал үүссэн тохиолдолд нэмж хөрөнгө барьцаалуулахыг, бүрэн бүтэн байдлыг хангах үүргээ биелүүлэхгүй бол уг хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэхийг тус тус шаардах, барьцаа хөрөнгийг бусдын өмчлөлд хэсэгчлэн болон бүрэн шилжүүлсэн тохиолдолд Банкны барьцааны эрх хүчин төгөлдөр хэвээр байх ба гуравдагч этгээдээс барьцаа хөрөнгийг гаргуулан авах;
- 5.1.5 Зээлийн гэрээг цуцлах, гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас Банкинд учруулсан хохирлыг нэхэмжлэх;
- 5.1.6 Зээлийн гэрээний үүргээ биелүүлэхгүй, үүрэг зөрчигдсөн тохиолдолд барьцаа хөрөнгийг худалдахыг шаардах, худалдах дарааллыг тогтоох;
- 5.1.7 Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй бол Банк үүргийн гүйцэтгэлийг зээлдэгчээс шаардах эрхтэй;

- 5.1.8 Зээлдэгч нь зээлийн гэрээний хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү тооцон авах;
- 5.1.9 Энэ гэрээний шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх;
- 5.1.10 Гэрээнд заасан шаардлага хангагдаагүй тохиолдолд зээлийг зээлдэгчид олгохоос татгалзах;
- 5.1.11 Чалко /Chalco Trading Hong Kong Co., Limited/ компанитай байгуулсан А-11-040-2020Q1 тоот гэрээ болон ЕТТ-2019/340, ЕТТ-2019/592, ЕТТ-2019/593 тоот гэрээнүүдийн орлогын нэхэмжлэлд ХААН Банкны 5004020200 тоот дансыг тусгах, орлогыг тус дансаар 100 хувь дамжуулахыг шаардах;
- 5.1.12 Талуудын хооронд байгуулсан барьцааны гэрээнд туссан Нүүрс худалдах, худалдан авах тухай ЕТТ-2019/340 тоот, ЕТТ-2019/592 тоот, ЕТТ-2019/593 тоот гэрээнүүдийн хугацааг 2022 оны 04 дүгээр сард багтаан сунгаж, гэрээний орлогыг ХААН Банкны 5004020200 тоот дансаар дамжуулахаар тусгахыг шаардах;
- 5.1.13 Зээл хугацаа хэтэрсэн тохиолдолд гэрээний орлогын 100 хүртэл хувиар зээлийн төлөлт хэвийн болгох хүртэл “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг харгалзахгүйгээр зээлийн төлбөрийг төлөхийг шаардах. Бусад банк, банк бус санхүүгийн байгууллагаас ХААН Банкны зээлийг оруулан нийт 400 тэрбум төгрөгөөс хэтэрсэн нэмэлт зээл авах тохиолдолд ХААН Банканд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авахыг шаардах;
- 5.1.14 Зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг, эд хөрөнгө хуваарилахгүй байхыг шаардах;

5.2 Банкны үүрэг:

- 5.2.1 Гэрээ хүчин төгөлдөр болсноор зээлийг гэрээнд заасан дансанд шилжүүлэх;
- 5.2.2 Зээлтэй холбоотой аливаа төлбөр тооцоо, бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэх;
- 5.2.3 Зээлдэгчийн зээлийн дансны хуулгыг гаргаж өгөх;
- 5.2.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 5.2.5 Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн нөхцөлд Банкны зээлийн журмын дагуу дахин зээл олгох, бусад урамшуулалд хамруулах;
- 5.2.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд барьцаа хөрөнгийг чөлөөлөх;

ЗУРГАА. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 6.1 Дараах тохиолдолд Банк нэг талын санаачилгаар гэрээг цуцалж, зээлийн төлбөрийг хугацаанаас өмнө бүрэн төлөхийг шаардах эрхтэй бөгөөд Банк нь аливаа холбогдох барьцааны гэрээ (нүүд)-ээр олгогдсон эрхээ хэрэгжүүлэх зэргээр (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) өөрийн эрхийг холбогдох хуулинд заасан дээд хэмжээнд хамгаалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах эрхтэй;
- 6.1.1 “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийг удаа дараа зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй;
- 6.1.2 Зээлдэгч худал мэдээлэл өгсөн, хуурамч баримт бүрдүүлэн зээл авсан;
- 6.1.3 Зээлдэгчээс Банкинд гаргасан аливаа тодорхойлолт, мэдэгдэл, баталгаа, зөвшөөрөл нь буруу буюу ноцтой тодоролд оруулахаар байгаа эсхүл болсон;
- 6.1.4 Зээлдэгч нь энэхүү Гэрээний дагуу эсхүл барьцааны гэрээ зэрэг Зээлдэгч, Банк нар тал нь болж оролцсон аливаа бусад Гэрээний дагуу хүлээсэн үүрэг, баталгаа, амлалтынхаа аль нэгийг биелүүлээгүй;
- 6.1.5 Зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа зогссон, эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл нь түдгэлзсэн, цуцалсан, хүчингүй болсон;
- 6.1.6 Банкнаас тавих зээлийн хяналт Зээлдэгч саад учруулсан;
- 6.1.7 Зээлдэгч энэхүү гэрээ буюу Барьцааны гэрээний дагуу хүлээсэн аливаа үүрэг, баталгаа, зөвшөөрөл, гэрээний бусад зүйл заалтыг зөрчсөн, эс биелүүлсэн;
- 6.1.8 Зээлдэгч аливаа өр, төлбөрөө хугацаанд нь төлөөгүй эсвэл аливаа өр төлбөрийг хугацаанаас өмнө төлөхийг Зээлдэгчээс гуравдагч этгээд шаардсан нь зээлийн гэрээний үүргийн биелэлтэд нөлөөлөхүйц эрсдэлтэй болсон гэж Банк үзсэн;
- 6.1.9 Зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан;
- 6.1.10 Зээлдэгч өөртэй нь эсвэл хөрөнгөтэй нь холбогдсон аливаа хууль, журам, шүүхийн шийдвэр эсхүл захирамжийг ноцтойгоор зөрчсөн;
- 6.1.11 Зээлдэгчийн эд хөрөнгийн аль нэг хэсгийг хураасан буюу устгасны улмаас үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон;
- 6.1.12 Барьцаа хөрөнгийн чанар, үнэлгээ буурсан, Зээлдэгч болон барьцаалуулагч нь Банкинд үл мэдэгдэн барьцаа хөрөнгийг өөрчилсөн, захиран зарцуулсан, устгасан, үрэгдүүлсэн, Зээлдэгч нэмж хөрөнгө барьцаалуулахаас татгалзсан;
- 6.1.13 Энэхүү гэрээний 2.2, 4.2.17-т заасан нөхцөл байдал үүсч зээлдэгч банкны тавьсан шаардлагыг биелүүлэхээс татгалзсан;
- 6.2 Банк гэрээний 6.1-д зааснаар гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн даруйд гэрээг цуцлаагүй нь энэхүү эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэхгүй.
- 6.3 Зээлдэгч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд Банк зээлийн гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, олгосон зээлийг нэн даруй буцаан төлөхийг Зээлдэгчээс шаардана.
- 6.4 Гэрээг цуцалсан нөхцөлд Банк зээлийг барьцаа хөрөнгөөр барагдуулах ажиллагаа хууль тогтоомжид заасны дагуу эхлүүлэх бөгөөд энэ тухай Зээлдэгчид мэдэгдэнэ.
- 6.5 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1 Зээлдэгч гэрээний хугацааг хэтрүүлсэн тохиолдолд энэ гэрээний 2.1.6-д заасан нэмэгдүүлсэн хүүг Банкинд төлнө.
- 7.2 Банк энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу Зээлдэгчээс зээл авах хүсэлт ирэхэд санхүүжилт олгох чадваргүй эсхүл олгохыг зогсоосон тохиолдолд Банк Зээлдэгчийн болон гуравдагч этгээдийн өмнө аливаа хариуцлага хүлээхгүй.
- 7.3 Зээлдэгч энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор талуудын хооронд 2022 оны 03-р сарын 28-ны өдөр байгуулсан БГХ22/13 тоот Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд тодорхойлсон хөрөнгийг барьцаа болгон барьцаалуулсан болно.
- 7.4 Энэхүү гэрээний 5.1.2-т заасан дансаас зээлийн төлбөрийг бүрэн барагдуулж хүрэлцэхгүй тохиолдолд, Банк энэ гэрээний салшгүй хэсэг болох Барьцаа/Баталгаат Ипотек/Батлан даалт/Фидуцийн гэрээнд зааснаар үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангуулна.

- 7.5 Барьцааны гэрээнд заасан хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн бусад орлого, хөрөнгөөр хангуулна.
- 7.6 Зээлийн гэрээний хугацаа дууссан нь гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй Зээлдэгчийг зээлийн төлбөр болон бусад төлбөрийг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Талууд энэ гэрээний зүйл заалтуудыг нэн тэргүүнд баримтална. Энэ гэрээгээр зохицуулагдаагүй бусад асуудал Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.
- 8.2 Энэ гэрээг Монгол хэл дээр 5 эх хувь үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар, хэрэв талуудын аль нэг нь хүссэн бол гэрээг нотариатаар гэрчлүүлснээр, хэрэв хуульд зааснаар холбогдох гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх шаардлагатай бол уг гэрээ бүртгэгдсэн өдрөөс энэхүү зээлийн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 8.3 Энэ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд гагцхүү бичгээр үйлдэх бөгөөд энэхүү гэрээний 8.2-т заасан нөхцөл хангагдсанаар хүчин төгөлдөр болно.
- 8.4 Энэхүү гэрээний дагуу үйлдэгдэх хавсралт Барьцааны гэрээ, Гэрээний нэмэлт өөрчлөлт нь түүний салшгүй хэсэг болох бөгөөд эдгээр гэрээгээр хүлээсэн үүргийг зөрчвөл зээлийн гэрээг зөрчсөнтэй адилтган тооцно.
- 8.5 Үүргийн гүйцэтгэлийг шүүхээс гадуур хангуулахаас бусад энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг талууд Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.6 Гэрээний 2.1.3.4 (ё) болон 2.2.6-д зааснаас бусад тохиолдолд энэ гэрээ, Барьцааны гэрээний гүйцэтгэлийн холбогдох мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэн талуудад биечлэн, эсвэл талуудын энэхүү гэрээнд заасан хаягаар баталгаат шуудангаар хүргүүлснээр хүлээн авсанд тооцно.
- 8.7 Гэрээ нь талууд, тэдгээрийн эрх залгамжлагчид, зөвшөөрөгдсөн шилжүүлэн авагчдын хувьд заавал биелэгдэх шинжтэй, хүчин төгөлдөр хэвээр байна.

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭГ ЗӨВШӨӨРЧ, БАЙГУУЛСАН:

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ
Байгууллагын Банк Хариуцсан Дэд Захирагч:




Ахтах харилцааны менежер:

(гарын үсэг)
С.Мөнхтулга
(нэр)

Гэрээ бэлтгэсэн мэргэжилтэн: Э.Балжинням

ЗЭЭЛДЭГЧ
Эрдэнэс Тавантолгой ХК, түүнийг төлөөлж
Гүйцэтгэх Захирал:



2022 оны 03-р сарын 28-ны өдөр байгуулсан
ЗГ22/13 тоот Зээлийн гэрээний Хавсралт 1

ЗЭЭЛ ОЛГОЛТ, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

Төлөлтийн дугаар	Огноо	Хүү тооцсон хоног	ЗЭЭЛ ОЛГОЛТ	ЗЭЭЛИЙН ТӨЛБӨР			Зээлийн үлдэгдэл
				Үндсэн зээл	Хүү	Нийт	
	03/28/2022		70,000,000,000.00				70,000,000,000.00
1	04/28/2022	31		0.00	891,780,821.92	891,780,821.92	70,000,000,000.00
2	05/28/2022	30		0.00	863,013,698.63	863,013,698.63	70,000,000,000.00
3	06/28/2022	31		0.00	891,780,821.92	891,780,821.92	70,000,000,000.00
4	07/28/2022	30		0.00	863,013,698.63	863,013,698.63	70,000,000,000.00
5	08/28/2022	31		0.00	891,780,821.92	891,780,821.92	70,000,000,000.00
6	09/28/2022	31		0.00	891,780,821.92	891,780,821.92	70,000,000,000.00
7	10/28/2022	30		23,333,400,000.00	863,013,698.63	24,196,413,698.63	46,666,600,000.00
8	11/28/2022	31		23,333,400,000.00	594,519,698.63	23,927,919,698.63	23,333,200,000.00
9	12/28/2022	30		23,333,200,000.00	287,669,589.04	23,620,869,589.04	0.00
Нийт дүн			70,000,000,000.00	70,000,000,000.00	7,038,353,671.23	77,038,353,671.23	

ЗӨВШӨӨРСӨН

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ
Байгууллагын Банк Хариуцсан Дэд Захирал:



Ахлах хариуцааны менежер:

(гарын үсэг)
С.Монхтулга
(нэр)

Гэрээ бэлтгэсэн мэргэжилтэн: Э.Балжинням



ЗЭЭЛДЭГЧ
Эрдэнэс Тавантолгой ХК-гүүнийг төлөөлж
Гүйцэтгэх Захирал:

(гарын үсэг)
Б.Ганхуяг
(нэр)
JSC

